

ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГ
БАЙГУУЛАХ
ТӨСӨЛ

МҮХАҮТ

Д.Баярцэнгэл боловсруулав.
2013 он

ГАРЧИГ

1. Төслийн товч танилцуулга
 2. Төслийн хэрэгцээ шаардлага
 3. Төслийн зорилго, зорилтууд, төсөл хэрэгжих үе шат
 4. Зах зээлийн судалгаа, өрсөлдөөний орчин
 5. Байрлал
 6. SWOT шинжилгээ
 7. Үйл ажиллагааны төлөвлөгөө
 8. Хүний нөөц, бүтэц зохион байгуулалт
 9. Хөрөнгө оруулалт, санхүүжилт
 10. Эрсдэлийн менежмент
-

Нэг. Товч танилцуулга

Өнөөдөр боловсролын салбарт тулгараад байгаа гол асуудлын нэг бол цэцэрлэгийн хүртээмж билээ. Хүүхдэд хамгийн чухал боловсрол бол суурь боловсрол байдаг бөгөөд бүх хүүхдэд суурь боловсролыг олгох нь төр засгийн нэг гол зорилт юм. Бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах нь бие бялдар, оюун ухааныг хөгжүүлж, нийгэмшүүлэхэд чухал ач холбогдолтой. Цэцэрлэгт явж байгаагүй хүүхдүүд сургуульд ороод сайн сурч чаддаггүй, юм сурахдаа бусдаасаа харьцангуй удаан байдаг гэсэн яриа байдаг.

Төсөлд 210 сая төгрөгний хөрөнгө оруулалт бүхий 100 хүүхдийн цэцэрлэг байгуулах ТЭЗҮ-г боловсрууллаа. Цэцэрлэг байгуулах байшинг түрээсээр ашиглах бөгөөд ахлах, дунд, бага ангид хувааж, улсаас баталсан сургалт, хүмүүжлийн ажил явуулахаас гадна дугуйлан, секц, гоо сайхны хүмүүжил олгох хичээл, хүүхдийн баяр, өглөөлөг зохиох, театр, музей, үзэсгэлэн рүү аялал зохион байгуулах зэрэг нэмэлт хичээл орох юм. Эцэг эхээс төлбөр авах замаар зардлаа нөхөх чиглэл баримтлана.

Манай орны аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа нь жигдэрч, цар хүрээ нь томрох тусам бизнесийн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд анхаарах боллоо. Ялангуяа тодорхой асуудлууд шийдэхэд хувийн хэвшлийнхэн оролцох болсны нэг нь цэцэрлэг, сургуулийн асуудал юм. Зарим томоохон компаниуд дэргэдээ сургууль, цэцэрлэг байгуулж, ажилтнуудынхаа үр хүүхдийг сургаж хүмүүжүүлж буй сайхан жишээ гарсаар байна. Олон компаниуд, аж ахуйн нэгжүүд дэргэдээ цэцэрлэг байгуулах сонирхолтой байна. Иймд тэдгээр аж ахуйн нэгж, байгууллагад зориулан цэцэрлэгийн загвар төсөл боловсрууллаа.

Хоёр. Төслийн хэрэгцээ шаардлага

Манай улсын хэмжээнд 945 цэцэрлэг байдаг. Үүнд 181 мянган хүүхэд хүмүүждэг гэсэн статистик тоо бий. Цэцэрлэгүүд хүчин чадлаа хэтийдүүлэн ажиллаад ч хүүхдээ шингээж чадахгүй болсныг мэргэжлийн байгууллагынхан хэлдэг. Монголд 56 мянган хүүхэд буюу 10 хүүхэд тутмын гурав нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадалгүй гэртээ үлддэг аж. Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх насны 100,000 орчим хүүхэд байдгаас 29.5 мянган буюу 10 хүүхдийн гурав нь цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй гэж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын байцаагч нар дүгнэжээ.

Хичээлийн жил эхлээд эцэг, эхчүүд хүүхдээ яаж цэцэрлэгт багтаах вэ гэж шогширдог. Мөнгөтэй, арга зальтай нэг нь балчир хүүхдээ харъяалал харгалзахгүйгээр “албанд” багтаачихдаг. Энэ нь тэдний буруу биш. Нийслэлийн хороодоор жишээ авахад огт цэцэрлэггүй хороо дүүргүүдэд цөөнгүй байдаг. Гэвч манай хороо цэцэрлэггүй гээд хүүхдээ гэртээ цоожилдог, хүүхдээ хараад үлддэг аав, ээж сүүлийн жилүүдэд цөөрсөн. Айл бүр л ямар нэг хэмжээгээр банкны өр, зээлтэй учраас эцэг, эхийн хэн нэг нь хүүхдээ хараад гэртээ суудаг үе өнгөрсөн. Хот, суурин газрынхан цэцэрлэгийн үүдээр хүүхдээ оруулсан бол өөрсдийгөө их ажил амжуулсанд тооцдог болжээ. Хүүхэд харах хүн хайлгүй цэцэрлэгт өгөөд ажлаа хялбар хийж байвал томчуулын санаа амрах нь тэр. Гэтэл төрийн өмчийн цэцэрлэгүүдэд нэг бүлэгт байх хүүхдийн тоо 1.5-2 дахин их болжээ.

2013 онд улсын хэмжээнд 95 цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 3900 ортой 36 цэцэрлэгийн барилга, 3200 хүүхдийн хүчин чадалтай 106 гэр цэцэрлэг, тавилга, тоног төхөөрөмжийн хамт нийлүүлэхээр төлөвлөсөн гэж БШУЯ-наас гаргасан статистик мэдээнд дурджээ. Дээрх байдлыг өнгөрсөн оныхтой харьцуулахад цэцэрлэгийн хүчин чадлыг 3.8 хувиар, гэр цэцэрлэгийг 10.5 хувиар нэмэгдүүлсэн гэв. Жилд цэцэрлэгийн тоог 3.8 хувиар ахиулж байхад энэ салбарт ахиц, дэвшил гарах уу.

Түүнээс гадна сүүлийн арваас арван таван жил хүүхдээ, ач нараа хувийн цэцэрлэгт өгч хүмүүжүүлэхэд дээр гэж үздэг дундаж анги бий болжээ. Эдгээр эцэг эхчүүд төрийн үйлчилгээнээс татгалзаж байгаа үндэслэлээ хүүхдийнхээ төлөө оруулж буй хөрөнгө оруулалт гэж тайлбарладаг. Төрийн боловсролын байгууллага нь хэт ачаалал, хөтөлбөрийн төгс бус байдал, ажилтны мэргэжлийн ур чадвар дутуу зэргээс болж зохих түвшний боловсролыг олгодоггүй. Төрийн цэцэрлэг хэт дүүрч, орон гарах бололцоогүйгээс гадна энэхүү цэцэрлэг нь хүүхдэд анхаарал халамж тавина гэх магадлал багатай юм. Ийм учраас өндөр зэрэглэлтэй мэргэжилтэн, сайн нөхцөл, чанартай үйлчилгээ, сайн чанартай хоолыг төлөхөд бэлэн байдаг. Иймээс манай оронд хувийн цэцэрлэг нь хөгжих

үндэслэлтэй бөгөөд хувийн цэцэрлэг нь цөөхөн учир өрсөлдөөн байхгүй байгаа билээ.

Өнгөрсөн хичээлийн жилд нийслэлд 308 цэцэрлэг бүртгэгдсэн. Үүний 128 нь төрийн бус өмчийн цэцэрлэг юм. Хувийн цэцэрлэгүүд бий болсноор хүрэлцээ багатай улсын цэцэрлэгүүдийн ачааллыг хуваалцаж багш, хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, оюуны чадавхи, ангийн онцлогт тохируулан ажиллах, хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчидтай ойр дотно хамтран ажиллах боломж түлхүү нээгдэх болно.

Энэхүү төсөлд хувийн цэцэрлэг байгуулах үе шат, санхүүгийн тооцоог үзүүллээ. Цэцэрлэгийг 100 хүүхэдтэй байгуулах бөгөөд сар тутам 200,000 төгрөгний төлбөр авна гэж тооцлоо.

Гурав. Төслийн зорилго, зорилтууд, төсөл хэрэгжих үе шат

3.1 Төслийн зорилго

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 19-р хорооны дэргэд 100 хүүхдийн хувийн цэцэрлэг байгуулж, ажиллуулна.

3.2 Төслийн зорилтууд

1. Хүүхдэд ээлтэй цэцэрлэг болгож, сургуулийн өмнөх насны багачуудыг саатуулах, чийрэгжүүлэх, сурган хүмүүжүүлэх тогтвортой тогтолцоог бий болгох
2. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх
3. Бага насны хүүхдийн боловсрол, хөгжилд эцэг эхчүүдийн мэдлэг, оролцоог сайжруулах
4. Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, 80- 100% дугуйланд хамруулах
5. Цэцэрлэгт хүүхдэд ээлтэй орчныг бий болгохын тулд шинэ стандарт, агуулгад нийцүүлэн тохилог орчин бүрдүүлэх, $\text{àòáðèàèèàã àààçùã áýðæ¿¿ëýõ}$
6. Эцэг эхийн оролцоо бүхий хяналтын хороо ажиллуулж цэцэрлэгийн өөрийн үнэлгээг бодитой болгож тайлагналтыг тогтмолжуулах

3.3 Төсөл хэрэгжиж үе шат



№	Хийх ажил	Эхний сар				2 дах сар				3 дах сар			
1	Цэцэрлэг байгуулах зөвшөөрлөө авна	■	■	■	■								
2	Байрандаа засвар хийнэ			■	■	■	■	■	■				
3	Тавилга, тоног төхөөмжөө авна				■	■	■	■	■				
4	Хүүдүүдээ бүртгэнэ					■	■	■	■				
5	Байраа бэлэн болгоно									■	■	■	■
6	Багш, ажилчидаа авч, сургалт бэлтгэнэ				■	■	■	■	■	■	■	■	■
7	Нээлтийн ажиллагаа											■	■
8	Цэцэрлэгийн ажиллагааг жигдрүүлнэ												■

Дөрөв. Зах зээлийн судалгаа, өрсөлдөөний орчин

4.1 Зах зээлийн судалгаа

Хан-Уул дүүргийн 19-р хороонд сургуулийн өмнөх насны 411 хүүхэд бүртгэлтэй бий. Эдгээр хүүхдүүдийн 200 гаруй нь цэцэрлэгт явж буй юм. Энэ хороонд төрийн өмчийн нэг цэцэрлэгтэй бөгөөд энэ цэцэрлэг 120 хүүхдийн багтаамжтай боловч 160 хүүхэд явж байна. Үлдсэн 40 гаруй хүүхэд нь өөр цэцэрлэгт явдаг байна.

Бид цэцэрлэггүй үлдсэн хүүхдүүдийн эцэг, эхийн дунд судалгаа хийсэн юм. Энэ судалгаанд 51 хүүхдийн эцэг буюу эх хамрагдсан байна.



Түүнээс гадна эцэг эхчүүдийн 96% буюу 49 нь хүүхдүүдээ цэцэрлэгт буюу түүнтэй төстэй газарт өгөх гарцаагүй шаардлага байна гэсэн нь цэцэрлэг байгуулах хэрэгтэйг харуулж байна. Тухайн төсөл нь амжилттай хэрэгжих нөхцөл бололцоо дүүрэн байгаа бөгөөд эрэлт нь нийлүүлэлтээсээ илүү байгаа юм.

4.2 Өрсөлдөөний орчин

Хан-Уул дүүргийн 19 хорооны орчим төрийн өмчийн нэг цэцэрлэг байгаа бөгөөд төслийн дагуу байгуулагдах цэцэрлэгт өрсөлдөгч болж чадахгүй юм. Түүнээс гадна ойр хавьд нь хувийн цэцэрлэг байхгүй учир өрсөлдөөний талаар ойрын 2-3 жилдээ санаа зоволтгүй.

Ойрын жилүүдэд төрийн зүгээс цэцэрлэг барина гэж төлөвлөсөн зүйл байхгүй байна. Эрэлт нь байгаа учир 1-2 хувийн цэцэрлэг байгуулагдаж болох бөгөөд тэр үед төслийн дагуу байгуулагдах манай цэцэрлэг нэгэнт хөлөө олсон байх болно.

4.3 Бизнес орчны анализ

Үндсэн хэрэглэгчид: УБ хотын Хан-Уул дүүргийн 19 -р хороодын иргэд болон ойр орчмын иргэд

Хэрэглэгчийн нийгмийн байдал: ажилчин, албан хаагч, бизнес эрхлэгчид

Орлогын түвшин: дундаж, дундажаас дээгүүр

Голдуу хүүхдийн цэцэрлэгээр дундаж орлоготой ажил хийгчид, дээгүүр орлоготой бизнес эрхлэгчид үйлчлүүлэх юм.


Тав. Байрлал

Цэцэрлэгийн байрлал нь хамгийн гол үүрэгтэй юм. Байрлал нь хүүхдүүдийн гэрийн төвд байхаас гадна хүүхдүүдийн аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбоотой юм. Түүнчлэн энэхүү бизнесийн цаашдын хөгжил ч байрлалаас хамаарах билээ.

Цэцэрлэг нь “Хүч” компанийн байрны 2 давхрын 150 кв.м талбайтай байранд байрлах болно. Худалдаа, үйлчилгээний төв, үйлдвэрийн районаас зайдуу, төв замаас ойрхон, хашаан дотор байрлал нь цэцэрлэг байгуулахад оновчтой, тохиромжтой юм. Цэцэрлэгийн байнаас 100 орчим метрт автобусны буудал байна.

Байраа дахин төлөвлөж, засвар хийлгэнэ. Тоглоомын өрөө, унтлагын өрөө, эмчилгээний өрөө, захирлын өрөө, ариун цэврийн өрөө, гал зуух, хоолны өрөө, хувцас тайлах өрөөг тус тусад нь хийнэ.

Зураг 3. Цэцэрлэгийн дотоод зохион байгуулалт



Хүүхдэд зориулсан тавилга, тоног төхөөрөмжөөр тоноглоно.



Зураг 4. Хүүхдийн өрөө

Гадна талд нь хүүхдийн талбай байгуулна.



Зураг 5. Гадна байдал

Зургаа. SWOT шинжилгээ

Давуу талууд	Сул талууд
<ul style="list-style-type: none"> • Багш хүүхэд нэгбүртэй тулж ажиллаж чадна • Хоол сайн, амттан, жимс өгнө • Цагийн хуваарь чөлөөтэй, 20 цаг хүртэл хүүхдээ авч болно • Сургалтын хөтөлбөр шинэлэг • Сувилагч, дуудлагаар эмч ажиллана 	<ul style="list-style-type: none"> • Ажлын туршлага байхгүй • Маркетингийн туршлага дутах • Нэр хүнд алдагдах
Боломж	Аюул
<ul style="list-style-type: none"> • Төр засгаас хувийн цэцэрлэгийг дэмжих байгаа • Шинэлэг олонд хүрсэн маркетингийн бодлого 	<ul style="list-style-type: none"> • Эдийн засаг унаж, иргэдийн төлбөрийн чадвар буурах • Өрсөлдөгчид гарч ирэх

Долоо. Үйл ажиллагааны төлөвлөгөө

7.1 Байр, тасалгаа бэлтгэх

Хүүхдэд дараах өрөө, байрыг бэлтгэнэ:

- Хүүхдийг хөгжүүлэх хичээлийн байр, чөлөөт тоглоомын байр (тоглоом, бичгийн хэрэгсэл, хүүхдийн тавилга, тоног төхөөрөмж)
- Хөгжмийн хэрэгсэлтэй ажлын байр
- Биеийн тамир, хөдөлгөөнт тоглоомын тоног төхөөрөмж, тоглоом
- Унтлагын өрөө (хүүхэд болгон хөнжил, гудас, 2 цагаан хэрэглэл)
- Гадуур хувцас тайлах өрөө (хувийн шкаф, буйдан)
- Хооллох өрөө (аяга, таваг, халбага сэрээ, тавилга)
- Ариун цэврийн өрөө (хөтөвч, алчуур, дагалдах хэрэгсэл)

Түүнээс гадна дараах өрөөг тоноглож бэлтгэнэ:

- Гал зуух (хоол бэлтгэх сав суулга, плитка, газын хэрэгсэл, печь, тавилга)
- Эмнэлгийн өрөө (тавилга, тусгай тавилга, эмнэлгийн багаж хэрэгсэл, хөргөгч)

7.2 Цэцэрлэгийн ажиллах горим, үйлчилгээ

Цэцэрлэг нь ийм горимоор ажиллана. Үүнд:

- Ажлын өдөр, өглөөнөөс (8-10) орой (18-20) хүртэл
- Амралтын өдөр, нэмэгдэл хөлсөөр

Улсаас баталж өгсөн сургалт, хүмүүжлийн ажлуудын хажуугаар дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Дугуйлан, секц
- Гоо сайхны хүмүүжил-хөгжим, бүжиг, уран зураг, дуу дуулах
- Өдрийн горим нь янз бүр
- Хүүхдийн баяр, өглөөлөг
- Театр, музей, үзэсгэлэн рүү аялал зохион байгуулах

Нэмэлт үйлчилгээ

- Өглөө хүүхдүүдийг явж цуглуулах, орой хүргэж өгөх үйлчилгээ үзүүлэх
 - Амралтын өдөр буюу хоногоор хүүхдээ орхих
 - Хүүхдийн сэтгэл зүйч туслах
-

7.3 Цэцэрлэгийн зохион байгуулалт

Цэцэрлэг нь хүүхэд авах чөлөөт горимтой бөгөөд 8 цагаас эхлэн 10 цаг хүртэл хүүхэд авна. Орой 18-20 цагаас болтол хүүхэд тарааж өгөхөөс гадна хүргэж өгөх үйлчилгээ үзүүлнэ.

Хагас, бүтэн сайн өдөр амрах боловч амралтын өдрүүдээр, хоногоор хүүхдээ орхих нэмэлт үйлчилгээ үзүүлнэ.

Цэцэрлэг нь бага, дунд, ахлах гэсэн 3 ангитай. Анги бүр тоглоомын танхим, унтлагын өрөө хэсэг хоёр хэсгээс бүрдэх ангитай. Мөн анги бүрт угаалгын машинтай.

Эмчийн өрөө тусдаа. Уураар утах аппарат ажиллаж, хүүхдүүдийн хоолойг утаж, ханиад томуунаас сэргийлнэ. Мөн шаардлагатай нөхцөлд хэрэглэх эм тан бүрд байна.

Цэцэрлэг нь иж бүрэн тоноглогдсон гал тогоотой. Гал тогоондоо 1, 2 дугаар хоолны гал тогоо, төмс шарагч, гурил зуурагч, печь гээд бүхий л хэрэгсэлтэй. Өдөртөө таван хоол өгнө.

Багш нарын өрөөнөөс эрхлэгч бүх ангиа камераар хянана. Багш нар юу зааж байна, хүүхдэд аюулгүй байдлыг хангаж байна уу, үгүй юу гэдгийг хянана.

Үйл ажиллагаа		Бүлэг		
		Бага	Дунд	Ахлах
Өглөөний үйл ажиллагаа	Өглөөний хүлээн авалт	07.30 - 8.30	07.30 - 8.30	07.30-8.30
	Өглөөний дасгал	8.30 - 8.45	8.30 - 8.40	8.30 - 8.40
	Өглөөний цайлалт	8.45 - 9.10	8.40 - 8.55	8.40 - 8.55
	Ариун цэвэр, эрүүл ахуй	9.10 - 9.30	8.55 - 9.15	8.55 - 9.15
Өдрийн үйл ажиллагаа	Хичээл – I цаг	9.30 - 9.45	9.20 - 9.45	9.20 - 9.45
	Хичээл – II цаг	-	9.50 - 10.10	9.50 - 10.15
	Хөгжүүлэх үйл ажиллагаа	9.45- 9.55	10.10 -10.30	10.20 - 10.45
	Наадам /Үдийн цай/	9.55 -10.10	10.35 - 10.50	10.50 -11.05
		10.10 - 10.25		
	Зугаалга	10.25 - 10.55	10.50 - 11.20	11.05 - 11.35
	Ариун цэвэр, эрүүл ахуй	10.55 - 11.30	11.20 - 11.45	11.35 - 11.55
	Өдрийн хоололт	11.30 – 12.00	11.45 - 12.15	11.55 -12.25
	Ариун цэвэр , эрүүл ахуй	12.00 -12.30	12.15 - 12.35	12.25 -12.45
	Нойрсолтод бэлтгэх, нойрсолт	12.30 - 14.50	12.35 - 15.00	12.45 -15.00
	Чийрэгжүүлэлт, ариун цэвэр, эрүүл ахуй	14.50 - 15.30	15.00 - 15.35	15.00 -15.35
Оройн үйл ажиллагаа	Оройн цайлалт	15.30 - 15.50	15.35 - 15.50	15.35 -15.50
	Хөгжөөн баясгах ажил, наадам	15.50 - 16.05	15.50 - 16.10	15.50 -16.15
	Хөгжүүлэх үйл ажиллагаа			16.15 -16.30
	Тоглоом наадам	16.05 - 16.30	16.10 - 16.30	
	Оройн таралт	16.30 - 17.30	16.30 - 17.30	16.30 - 17.30

Найм. Хүний нөөц, бүтэц зохион байгуулалт

Хүүхдийн цэцэрлэгт МУБИС-ийг бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн, багшлах эрхээ авсан хүн багшлах ёстой байдаг. Цаашилбал, тухайн багш маань мэргэжлийн зэрэгтэй болох ёстой. Төслийн дагуу байгуулагдах цэцэрлэгт хүмүүжүүлэгч, туслах багшаар 30 дээш насны, өмнө нь цэцэрлэгт ажиллах байсан хүн авна.

Цэцэрлэгийн хүний нөөцийн санд дараах албан тушаалтнууд орно. Үүнд:

- Эрхлэгч
- Хүмүүжүүлэгч
- Туслах багш
- Сувилагч
- Тогооч
- Цэвэрлэгч
- Хамгаалагч

8.1 Эрхлэгч

- Эрхлэгч нягтлан бодохын үүргийг гүйцэтгэнэ.
- Өдөр тутмын ажлыг зохион байгуулна
- Байгууллагыг төлөөлнө, гэрээ хэлэлцээр байгуулна
- Цэцэрлэгийн хөрөнгийг захиран зарцуулна
- Хууль тогтоомжтой холбоотой тушаал, захирамж гаргана
- Ажилтнуудыг авах, цалин, ажил үүргийн хуваарийг тогтоох, халах
- Цэцэрлэгийн төлөвлөгөө, цаашдын зорилтыг тодорхойлох

8.2 Хүмүүжүүлэгч, туслах багш

- Хүмүүжүүлэх, сургах хичээл орох
- Дуу хөгжмийн хичээлийг заах
- Хүүхдийн аюулгүйн байдалд хяналт тавих
- Хүүхдүүдийг хооллох
- Зугаалгаар явах, аялал хийх
- Баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулах
- Эцэг эхийн хурал хийх

8.3 Цэвэрлэгч

- Тасалгаануудыг арчих, цэвэрлэх
 - Орыг хураах, цэвэрлэх
 - Цагаан хэрэглэл, алчуурыг угааж индүүдэх
-

8.4 Сувилагч

- Хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр хөтөлнө
- Эрүүл мэндийн үйлчилгээ, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлнэ
- Хүүхдүүдэд тарилга, вакцин хийнэ

8.5 Тогооч

- Өглөө, өдөр, оройн хоолыг бэлтгэнэ

8.6 Хамгаалагч

- Цэцэрлэгийн байшин, түүний ойролцоох нутаг дэвсгэрийн хамгаална

8.7 Ажлын цаг

1. Захирал 9:00-19:00
 2. Хүмүүжүүлэгч 8:00-17:00
 3. Туслах багш 9:00-19:00
 4. Сувилагч 10:00-16:00
 5. Цэвэрлэгч 9:00-18:00
 6. Тогооч 8:00-17:00
 7. Хамгаалагч 6:00-18:00
-

Ес. Хөрөнгө оруулалт, санхүүжилт**9.1 Хөрөнгө оруулалт**

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Хэмжээ
1	Засвар хийх зардал	25,000,000
2	Галын аюулаас урьдчилан сэргийлэх төхөөрөмж	4,000,000
3	Тавилга	75,000,000
4	Ор, хөнжил, даавуу	8,000,000
5	Сургалтын материал, тоглоом, хөгжим г.м авах	26,500,000
6	Электрон төхөөрөмж авах (хөргөгч, плитка г.м)	31,000,000
7	Камер, телефон тавих	11,000,000
8	Эхний 3 сарын цалин	19,350,000
9	Эхний 3 сарын түрээс	6,000,000
10	Бусад зардал	5,000,000
	НИЙТ	210,850,000

9.2 Орлого

№	Орлогын төрөл	Сард	Жилд
1	Төрөөс өгөх мөнгө	11,600,000	116,000,000
2	Төлбөр	20,000,000	200,000,000
	НИЙТ	31,600,000	316,000,000

Орлого, зарлагыг 3 жилээр тооцсон бөгөөд жил тутам 8 хувиар өсгөж тооцлоо.

9.3 Зардал

9.3.1 Цалин

№	Албан тушаал	Тоо	Сарын цалин	Сарын цалингийн фонд	Жилийн цалингийн фонд
1	Эрхлэгч	1	700,000	700,000	8,400,000
2	Хүмүүжүүлэгч	3	600,000	1,800,000	21,600,000
3	Туслах багш	3	500,000	1,500,000	18,000,000
4	Сувилагч	1	550,000	550,000	6600 000
5	Тогооч	1	700,000	700,000	8 400 000
6	Цэвэрлэгч	1	400,000	400,000	4 800 000
7	Хамгаалагч	2	400,000	800,000	9 600 000
	НИЙТ			6,450,000	77 400 000

9.3.2 Үйл ажиллагааны зардал

№	Зардлын төрөл	Сарын	Жилийн
1	Хоолны зардал	6,500,000	65,000,000
2	Байрны түрээс	2,000,000	20,000,000
3	Зар сурталчилгаа	1,000,000	10,000,000
4	Газрын төлбөр	1 удаа	3,500,000
5	Барилгын элэгдэл, хорогдол	1 удаа	2,800,000
6	Хөдөлмөр хамгааллын зардал	500,000	5,000,000
7	Аж ахуйн зардал	1,600,000	16,000,000
8	Үйл ажиллагааны хангамжийн зүйлс	1,500,000	15,000,000
9	Шуудангийн зардал	600,000	6,000,000
10	Засвар	1 удаа	20,000,000
11	Цахилгаан, ус, халаалт	1,200,000	12,000,000
12	Бусад зардал	500,000	5,000,000
	НИЙТ ЗАРДАЛ		180,300,000

9.3.3 Нийт жилийн зардал

№	Зардлын төрөл/Нийт зардал	2014	2015	2016
1	Ажилтны цалин	77,400,000	83,592,000	90,279,360
2	НДШ, ЭМД	8,901,000	9,613,080	10,382,126
3	Шагнал урамшуулал	10,000,000	10,800,000	11,664,000
4	Хоолны зардал	65,000,000	70,200,000	75,816,000
5	Байрны түрээс	24,000,000	25,920,000	27,993,600
6	Зар сурталчилгаа	10,000,000	10,800,000	11,664,000
7	Газрын төлбөр	3,500,000	3,780,000	4,082,400
8	Барилгын элэгдэл, хорогдол	2,800,000	3,024,000	3,265,920
9	Хөдөлмөр хамгааллын зардал	5,000,000	5,400,000	5,832,000
10	Аж ахуйн зардал	16,000,000	17,280,000	18,662,400
11	Үйл ажиллагааны хангамжийн зүйлс	15,000,000	16,200,000	17,496,000
12	Шуудангийн зардал	6,000,000	6,480,000	6,998,400
13	Засвар	20,000,000	21,600,000	23,328,000
14	Цахилгаан, ус, халаалт	12,000,000	12,960,000	13,996,800
15	Бусад зардал	5,000,000	5,400,000	5,832,000
	БҮГД	280,601,000	303,049,080	327,293,006

9.4 Үр ашгийн тооцоо

№	Үзүүлэлт /Хэмжээ	2014	2015	2016
1	Орлого	316,000,000	341,280,000	368,582,400
2	Зардал	280,601,000	303,049,080	327,293,006
3	Татварын өмнөх ашиг	35,399,000	38,230,920	41,289,394
4	Татвар (10 хувь)	3,539,900	3,823,092	4,128,939
5	Өөрт үлдэх ашиг	31,859,100	34,407,828	37,160,455

9.5 Мөнгөн гүйлгээний тайлан (оноор)

	2014	2015	2016
Бэлэн мөнгөний эхний үлдэгдэл	25,350,000	60,749,000	98,979,920
Бэлэн мөнгөний орлого:			
Авлагын барагдуулалт	0	0	0
Зээлийн хөрөнгө	0	0	0
Борлуулалтын орлого	316,000,000	341,280,000	368,582,400
Бусад орлого			
Бэлэн мөнгөний нийт орлого	316,000,000	341,280,000	368,582,400
Бэлэн мөнгөний зардал:			
Ажилтны цалин	77,400,000	83,592,000	90,279,360
НДШ, ЭМД	8,901,000	9,613,080	10,382,126
Шагнал урамшуулал	10,000,000	10,800,000	11,664,000
Хоолны зардал	65,000,000	70,200,000	75,816,000
Байрны түрээс	24,000,000	25,920,000	27,993,600
Зар сурталчилгаа	10,000,000	10,800,000	11,664,000
Газрын төлбөр	3,500,000	3,780,000	4,082,400
Барилгын элэгдэл, хорогдол	2,800,000	3,024,000	3,265,920
Хөдөлмөр хамгааллын зардал	5,000,000	5,400,000	5,832,000
Аж ахуйн зардал	16,000,000	17,280,000	18,662,400
Үйл ажиллагааны хангамжийн зүйлс	15,000,000	16,200,000	17,496,000
Шуудангийн зардал	6,000,000	6,480,000	6,998,400
Засвар	20,000,000	21,600,000	23,328,000
Цахилгаан, ус, халаалт	12,000,000	12,960,000	13,996,800
Бусад зардал	5,000,000	5,400,000	5,832,000
Бэлэн мөнгөний нийт зардал	280,601,000	303,049,080	327,293,006
Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл	60,749,000	98,979,920	140,269,314

Арав. Эрсдэлийн менежмент

Энэхүү төсөлд дараах эрсдэлүүд тохиолдоно. Үүнд:

Эрсдэлийн хүчин зүйлүүд	Сөрөг үр дагавар	Даван туулах нь
Төлбөр төлөх чадвар багасах	Эцэг эхчүүд төлбөрөө төлөх чадваргүй болж цэцэрлэгт явах хүүхдийн тоо буурна.	Зардлаа багасгаж, төлбөрийг дахин тогтооно.
Инфляц зэргээс болж урьдчилан төлөвлөөгүй зардал гарах	Ашиг буурна. Алдагдал хүлээж ч магадгүй.	Ашгаасаа фонд бий болгож, нэмэгдэл зардлыг фондоосоо төлнө.
Өрсөлдөөн ихэссэнээс болж үнэ буурах	Үнэ ихтэйгээс үнэ багатайд нь шилжинэ.	Зардлаа дахин хянан бууруулж, үнээ бууруулна.
Хоолны материалны үнэ өсөх	Хоолны зардал өснө.	Туслах аж ахуй хөгжүүлж, туслах аж ахуйгаас хоолны материалаа нийлүүлнэ.

Хавсралт 1

Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Хэмжээ
1	Засвар хийх зардал	25,000,000
a	хаалга хийх	4,500,000
b	тугаарлагч хана хийх	8,300,000
c	хана, таазандаа эмульс түрхэх	2,400,000
d	чимээ тусгаарлагч хийх	3,200,000
e	бусад засвар	6,600,000
2	Галын аюулаас урьдчилан сэргийлэх төхөөрөмж	4,000,000
3	Тавилга	75,000,000
a	офисын тавилга	6,500,000
b	эмчийн өрөөний тавилга, хэрэгсэл	12,000,000
c	гал зуухны тавилга	4,900,000
d	хоолны өрөөний тавилга	18,500,000
e	ор, матрац	23,000,000
f	сандал, ширээ	8,000,000
g	хувцасны тавилга, бусад	2,100,000
4	Ор, хөнжил, даавуу	8,000,000
5	Сургалтын материал, тоглоом, хөгжим г.м авах	26,500,000
a	хөгжим	6,200,000
b	сургалтын материал	4,800,000
c	тоглоом	12,000,000
d	бусад	3,500,000
6	Электрон төхөөрөмж авах (хөргөгч, плитка г.м)	31,000,000
a	хөргөгч, хөлдөөгч	3,000,000
b	плитка, цахилгаан зуух	7,000,000
c	печь, талх баригч, талх шарагч г.м	4,800,000
d	хоолны хэрэгсэл, хоолны сав г.м	9,800,000
e	индүү, угаалгын машин, тоос сорогч г.м	4,500,000
f	бусад	1,900,000
7	Камер, телефон тавих	11,000,000
8	Эхний 3 сарын цалин	19,350,000
9	Эхний 3 сарын түрээс	6,000,000
a	нэг сарын түрээс	2,000,000
10	Бусад зардал	5,000,000
	НИЙТ	210,850,000

Хавсралт 2

Үйл ажиллагааны зардалын задаргаа

№	Зардлын төрөл	Сарын	Жилийн
1	Хоолны зардал	6,500,000	65,000,000
	мах, махан бүтээгдхүүн	1,200,000	12,000,000
	гурил, гурилан бүтээгдхүүн	850,000	8,500,000
	төрөл бүрийн будаа	600,000	6,000,000
	төмс, хүнсний ногоо	650,000	6,500,000
	жимс, жимсгэнэ, лаазтай жимс	500,000	5,000,000
	элсэн чихэр, чихэр	800,000	8,000,000
	бусад	1,900,000	19,000,000
2	Байрны түрээс	2,000,000	20,000,000
3	Зар сурталчилгаа	1,000,000	10,000,000
	ТВ реклам		6,000,000
	ТВ зар		3,000,000
	FM реклам		1,000,000
4	Газрын төлбөр	1 удаа	3,500,000
5	Барилгын элэгдэл, хорогдол	1 удаа	2,800,000
6	Хөдөлмөр хамгааллын зардал	500,000	5,000,000
7	Аж ахуйн зардал	1,600,000	16,000,000
	тээврийн зардал	600,000	6,000,000
	аж ахуйн зардал	550,000	5,500,000
	бусад	450,000	4,500,000
8	Үйл ажиллагааны хангамжийн зүйлс	1,500,000	15,000,000
	ариун цэврийн хэрэгсэл	450,000	4,500,000
	хичээлийн хангамж	600,000	6,000,000
	бусад	450,000	4,500,000
9	Шуудан, бичиг хэргийн зардал	600,000	6,000,000
	бичиг хэргийн зардал	200,000	2,000,000
	шуудан, интернетын зардал	400,000	4,000,000
10	Засвар	1 удаа	20,000,000
11	Цахилгаан, ус, халаалт	1,200,000	12,000,000
12	Бусад зардал	500,000	5,000,000
	НИЙТ ЗАРДАЛ		247,300,000